



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 134


Номгон

**“Цэвэр хот” ХХК-ийг өөрчлөн  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, 77.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. “Цэвэр хот ХХК”-ийг “Цэвэр хот орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар” болгон өөрчлөн байгуулсугай.
2. “Цэвэр хот” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг удирдлага арга зүйгээр хангаж, үйл ажиллагааг үр дүнтэй шинэлэг бүтээлч байдлаар зохион байгуулахыг гүйцэтгэх захирал /Ц.Баясгалан/-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190703